


**ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
“БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ, ИРГЭН ТӨВТЭЙ УХААЛАГ ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ ЖИЛ”-ИЙН
ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ**

2019.11.28

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээг хэмжих шалгуур үзүүлэлт	Тухайн жилийн хүрэх түвшин	Төсөв, эх үүсвэр (мян.төг)	Хэрэгжилт	Хувь
1	“Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил”-ийн хүрээнд зохион байгуулах ажлын саналыг иргэд болон ТББ-аас авах, төлөвлөгөөнд нэмэлтээр тусгана.	- Иргэд, ТББ-тай уулзалт зохион байгуулах - Иргэд олон нийтээс санал асуулга авах - Нэрэмжит жилийн төлөвлөгөөг иргэд, олон нийтэд танилцуулах - Нэрэмжит жилийн хүрээнд зохион байгуулж байгаа ажлыг иргэдэд ил тод сурталцах - Орон нутгийн “Ард” телевиз болон хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй хамтарч ажиллах	- Иргэдээс ирүүлсэн саналыг төлөвлөгөөнд тусгасан байна. - Төлөвлөгөөг хэрэгжүүлж, хэрэгжилтийг олон нийтэд ил тод мэдээллэсэн байна.	500,0 ОНХС	Тус байгууллага 2019 оныг “Бүтээн байгуулалт, иргэн төвтэй ухаалаг газрын харилцааны жил” болгон зарласантай холбогдуулан нэрэмжит жилийн хүрээнд хийх ажлын төлөвлөгөөг боловсруулахдаа иргэдээс санал авч төлөвлөгөөнд тусгах зорилгоор орон нутгийн “Ард” телевизтэй хамтран иргэдийн дунд “Нээлттэй микрофон” аялуулж, санал авах ажлыг 2019 оны 2 дугаар сард зохион байгуулсан. Нийт 116 иргэн, албан хаагчийн саналыг авч нэгтгэхэд - Байгууллагын үйл ажиллагааг сурталчлах - Мэдээллийн цахим үйлчилгээг хүртээмжтэй болгох - Маягт мэдээллийг заавал мэргэжилтэн дээр очиж авахгүй цахимд байршуулах зэрэг санал ихэнх хувийг эзэлж байна. Дээрх саналыг нэрэмжит жилийн төлөвлөгөөнд тусгаж төлөвлөгөөг байгууллагын даргаар батлуулж 100 хувь хэрэгжүүлсэн.	100
2	Барилга, бүтээн байгуулалтын чиглэлээр танилцуулга хийж иргэдэд	- Видео танилцуулга бэлтгэх - Улс, орон нутгийн төсвөөр	- Орон нутагт хэрэгжсэн бүтээн байгуулалтын талаарх мэдээллийг сурталчлах, олон		2019 онд улс, орон нутгийн төсвөөр хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүдийн талаарх мэдээллийг олон нийтэд сурталчлах видео танилцуулгыг хийж www.dundgovi.gov.mn www.dundgovi.gazar.gov.mn сайтаар олон нийтэд сурталчилж ажилласан.	100

	сурталчилна.	хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүдийн талаарх мэдээллийг олон нийтэд хүргэх	нийтэд хүргэсэн байна.		 Дэлгэрхангай сумын 320 суудалтай сургуулийн барилга Төсөвт өртөг- 2.228.800.000₮ Хэрэгжих хугацаа: 2019 он	
3	Лабораторын үйл ажиллагааг нээнэ.	- Тоног төхөөрөмжийг угсрах - Лабораторийн өрөөг тохижуулах - Лабораторийн хэвийн үйл ажиллагааг хангах	- Барилга угсралтын ажилд хэрэглэгдэж буй түүхий эд, материал стандартын шаардлага хангасан байна. - Барилгын материалын чанарт тавих лабораторийн хяналт сайжирсан байна - Барилгын чанар дээшилсэн байна	54,6 сая ОНХС	Барилгын материалын лабораторийн үйл ажиллагааг 2019 оны 10 дугаар сарын 9-ний өдөр нээсэн. 2019 онд 49,9 тэрбум төгрөгийн 27 барилга, байгууламж, их засвар, тохижилтийн ажил байгаагаас он дамжсан 10, 2019 онд шинээр эхэлсэн 17 барилга байгууламж, тохижилт, засвар байна. 2019 онд 20 дээжинд шинжилгээ хийсэн байна.  2020 оны орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний жагсаалтад Арматурын байрлал, диаметр тодорхойлох багажны үнэ 25 сая төгрөгийг батлуулсан.	100

4	“Иргэн төвтэй төрийн үйлчилгээ” өдөрлөгийг зохион байгуулна.	- Гарын авлага бэлтгэх, бэлтгэл ажлыг хангах - Бүх сумдад “Иргэн төвтэй төрийн үйлчилгээ” өдөрлөгийг зохион байгуулах - Зохион байгуулсан ажлын тайланг гаргаж ГЗБГЗЗГ-т хүргүүлэх	- Иргэдэд газрын харилцаа, барилга, хот байгуулалтын чиглэлээр төрийн үйлчилгээг хүргэсэн байна. - Тайланг гаргаж ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн байна.	-	2019 оны 10 дугаар сарын 4-9-ны өдрүүдэд Баянжаргалан, Цагаандэлгэр сумдад, 11 дүгээр сарын 12-15-ны өдрүүдэд Дэрэн, Говь-Угтаал, Баянжаргалан сумдад , 1 дүгээр сарын 15-нд Сайнцагаан сумын 2-р багийн ИНХ, 4 дүгээр сарын 20-нд ахмадын цуглаан, 10 дугаар сарын 6-ны өдөр Боржигон багийн иргэдэд “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг зохион байгуулж - Газрын тухай хууль, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль, Хаягжуулалтын тухай хуулийг сурталчлах - Газрын харилцааны үйл ажиллагааг ил тод нээлттэйгээр мэдээллийг хүргэх - Салбарын хэмжээнд хэрэгжиж буй бодлогын талаар    иргэдэд мэдээлэл хүргэх - Газрын төлбөрийг шинэчлэн тогтоосон аймаг, сумын ИТХ-ын тогтоолын талаар мэдээлэл хүргэх - Газар эзэмших, ашиглах гэрээг дүгнэх - Газрын кадастрын зургаар үйлчлэх - Мэдээллийн санг шинэчлэх зэрэг үйлчилгээг хүргэсэн. Уг арга хэмжээнд шинээр газар өмчлөх 100 гаруй иргэний хүсэлтийг хүлээн авч, газраа өмчилж авсан 125 иргэнд кадастрын зургаар үйлчилж, гарын авлага, материал тарааж, давхардсан тоогоор нийт 550 гаруй иргэнд салбарын үйл ажиллагааг сурталчилж, үйлчилгээг 
---	---	---	---	---	---

5	“Ухаалаг газрын харилцаа үйлчилгээ”-г нэвтрүүлнэ.	- Төхөөрөмж ийг судлах - Програмчл алийг хийх - Газрын харилцаа болон барилга, хот байгуулалтын чиглэлээр иргэдэд хүргэх үйлчилгээнд ухаалаг системийг нэвтрүүлэх	- Цахим төхөөрөмж ашиглалтад орж иргэд газрын харилцаа болон барилга, хот байгуулалтын чиглэлээр үйлчилгээг ухаалаг системээр авах нөхцөл хангагдсан байна	1 сая ОНХС	Бүтээн байгуулалт, иргэн төвтэй ухаалаг газрын харилцаа нэрэмжит жилийн хүрээнд байгууллагын коридорт 55 инчийн төрийн үйлчилгээ үзүүлэх ухаалаг дэлгэцийг байршуулсан. Дээрх ухаалаг дэлгэцнээс иргэдэд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой цаг үеийн мэдээлэл, газрын биржийн цахим мэдээллийн сангаас газрын дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалт, үнийн мэдээ, түрээс, худалдааний мэдээлэл болон цахим мэдээллийн сангаас өөрийн газрын мэдээллийг харах, батлагдсан Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг харах, төслийн шатны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд санал өгөх, Газрын хянан баталгаа, Мониторингийн сүлжээний мэдээллийг харах боломж бүрдлээ. 	
6	Газар чөлөөлөх үйл ажиллагааг зохион байгуулна.	- Судалгаа гаргах - Телевизийн мэдээлэл бэлтгэж иргэдэд хүргэх - Иргэд, ААН байгууллагуудад мэдэгдэл хүргүүлэх - Холбогдох хууль тогтоомжийн дагуу газар	- Хууль бусаар төрийн өмчийн газрыг зөвшөөрөлгүй ашигласан иргэн, ААНБ-ын газрыг холбогдох хуулийн дагуу чөлөөлсөн байна.	-	- 2019 оны 1 дүгээр улиралд зохих зөвшөөрөлгүй дур мэдэн газар ашиглаж байсан 25 иргэн, ААНэгжийн судалгааг гаргасан. - Газар чөлөөлөх талаар нэвтрүүлэг бэлтгэж орон нутгийн Ард тв-ээр олон нийтэд хүргэсэн.	100

		чөлөөлөх үйл ажиллагааг зохион байгуулах			- Газрын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.4 заалтыг зөрчин дур мэдэн газар ашиглан чингэлэг, амбаар, ёмкост тавьсан иргэн, ААНэгжүүдийн газрыг чөлөөлөх тухай аймгийн Засаг даргын 2019 оны 6 дугаар сарын 4-ний өдрийн А/227 дугаар захирамжийн дагуу аймгийн төвд зөвшөөрөлгүй газар ашиглаж байгаа иргэд ААНэгжүүдэд газар чөлөөлөх хугацаатай мэдэгдлийг өгч 21 байршлын газрыг чөлөөллөө. Мөн мэдэгдэлд заасан хугацаанд газар чөлөөлөөгүй 4 иргэн, ААНэгжид аймгийн Мэргэжлийн хяналтын газраас Зөрчлийн тухай хуулийн дагуу торгуулийн арга хэмжээ авахуулж ажилласан. 	
7	“Дундговь хөтөч” аппликейшн хэрэглээнд нэвтрүүлнэ.	- Гар утасны аппликейшн хөгжүүлдэг, програмчлал хийдэг аж ахуй нэгжүүдтэй холбоо	- Хаягийн мэдээллийн санд суурилагдсан аймгийн ухаалаг газрын зургийн аппликейшнийг хөгжүүлж	-	Дундговь аймгийн хэмжээнд 2016 оноос хойш газрын харилцааны салбарт улсын болон орон нутгийн төсөв хөрөнгөөр зохион байгуулж хэрэгжүүлсэн томоохон ажлуудын үр дүнд олон тооны тоон мэдээлэл, мэдээллийн сангууд шинэчлэгдэн баяжигдсан билээ. Өмнөх онуудад улсын болон орон нутгийн төсөв хөрөнгөөр зохион байгуулагдаж бүрдсэн мэдээллийн сангууд:	100

		тогтоох, судалгаа хийх - Хаягийн мэдээллийн санд суурилагдсан ухаалаг газрын зургийн системийг хэрэглээнд нэвтрүүлэх - Хөгжүүлэлтийг хийх	хэрэглээнд нэвтрүүлсэн байна. - Иргэд төрийн байгууллагууд үр шимийг хүртсэн байна	- 2013 онд Улсын төсвийн хөрөнгөөр хийгдсэн “Сумын хилийн цэсийн эргэлтийн цэгийг координатжуулах ажил”-ын үр дүн - 2016 онд Улсын төсвийн хөрөнгөөр хийгдсэн “Хаягийн мэдээллийн санг бүрдүүлэх гэрээт ажил”-ын үр дүн - 2018, 2019 онуудад “Сум суурин газрыг стандарт хаягийн тэмдэгжүүлэх ажил”-уудын хүрээнд шинэчлэн засварлаж газар дээр нь байрлуулсан тэмдэг хаягийн зургийн зөрүүгүй болсон 15 сумын ХАЯГИЙН МЭДЭЭЛЛИЙН САН - 2018 онд “Аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах ажил”-ын хүрээнд хийгдсэн аймгийн нийт нутаг дэвсгэрийн хөрсөн болон бусад төрлийн АВТО ЗАМЫН СҮЛЖЭЭНИЙ ТООН ЗУРАГ /сансрын зургаас зурж 2018 онд “Геодезийн байнгын цэг тэмдэгтийг газар дээр нь очин тоолох ажил”-ын хүрээнд шалгагдсан хөрсөн зам/ - 2017, 2018 оны “Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажил”-ын хүрээнд хийгдсэн өвөлжөө хаваржааны доорх газрын судалгаа, хэмжилтийн ажил, “Лэнд менежер -2” програм хангамжийн НӨХӨН БҮРДҮҮЛЭЛТ-ийн ажлын хүрээнд хийгдсэн ӨВӨЛЖӨӨ, ХАВАРЖААНЫ ДООРХ ГАЗАР ЭЗЭМШИГЧДИЙН БҮРТГЭЛТЭЙ МЭДЭЭЛЛИЙН САН - 2017, 2018 онд “Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажил”-ын хүрээнд тодруулагдсан аялал жуулчлал, байгалийн үзэсгэлэнт газар, түүх соёлын дурсгалт ГАЗРУУДЫН МЭДЭЭЛЭЛ - 2019 онд аймгийн ИТХ-аар батлагдсан 15 сумын 68 багийн заагийн мэдээлэл Дээрх мэдээллүүд байгаа боловч арга хэмжээнүүдийн үр дүнгээр иргэд, олон нийт, албан байгууллагыг хангах, тэдэнд хүргэх боломжийг ойртуулах, мөн 2019 оныг “Бүтээн байгуулалт, иргэн төвтэй, ухаалаг газрын харилцаа”-ны жил болгон зарласантай холбогдуулан иргэд олон нийтэд өдөр тутам хэрэглэгдэх газрын харилцааны салбарт хийгдэж байгаа ажлыг танилцуулах ухаалаг төхөөрөмжийн хэрэглүүр зохиох, хөгжүүлэх, хэрэглээнд нэвтрүүлэх санал	
--	--	--	--	--	--

				санаачлагаыг гаргаж хэрэглээнд нэвтрүүлээд байна. Уг аппликейшн нь - Монгол хэлтэй - Ямар нэгэн сүлжээ харгалзахгүй ажиллах боломжтой - Дундговь аймгийн 15 сумын хаягийн мэдээллийн сан сүүлийн байдлаар орсон /хаягийн хайлтаар очих боломжтой/ - Аймгийн нутаг дэвсгэрээр дайран өнгөрөх улсын болон орон нутгийн чанартай хатуу хучилттай болон хөрсөн замын мэдээлэл 100 хувь орсон. - Худаг, уст цэг, томоохон уул, овоо, нуур цөөрмийн нэр, байршил орсон./1:200 000-ны масштабын нарийвчлалтай/ - Аймгийн нутаг дэвсгэр дэх бүх өвөлжөө, хаваржааны мэдээлэл багтаж чухал шаардлагатай Түргэн тусламж, Цагдаа, Онцгой байдлын алба, аймаг, сумын онцгой комисст цаг хугацаа, хөрөнгө хэмнэх бололцоог бүрдүүлсэн. /газар зүйн нэр, эзэмшигчийн нэрээр хайлт хийх боломжтой/ - Аймгийн 15 сумын хилийн цэс, 68 багийн зааг харагдах боломжтой - Хурд хэмжиж, зам тооцоолно - Сүүлийн үеийн газрын зургийн баяжилт автоматаар хийгддэг - Координатаар цэгийг хайх боломжтой - Явсан замаа бичиж, тэмдэглэл хийх боломжтой Өвөлжөө, хаваржааны нэр болон эзэмшигчээр хайх Байшин, хашааны хаягаар хайх	
--	--	--	--	---	--

